

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024.12.02

Улаанбаатар хот

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Үнэлгээ
"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ЭДИЙН ЗАСАГ БҮЛГИЙН ХҮРЭЭНД: ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1.ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.						
1.2.Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1.2.1.Олон улсын жишигт нийцсэн боомтын тоог нэмэгдүүлнэ.	АХ-7.2.7, МУХТЖҮЧ-7.2.3, ЗГҮАХ -4.3.1	1.2.1.1.Хилийн боом-туудад ухаалаг цахим гарц суурилуулах	Ухаалаг цахим гарц суурилуулах хилийн боомт	Монгол Улсын Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлт хийж буй жолооч нарыг улсын хилээр саадгүй, түргэн шуурхай нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэсний энгийн гадаад паспортыг иргэн өөрөө захиалах зориулалт бүхий цахим машиныг Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуун сухайт боомт, суурилуулсан.	100
"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ЗАСАГЛАЛ БҮЛГИЙН ХҮРЭЭНД: ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 7.ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.						
7.1. Авлигын үзүүлэлтийг сайжруулна.	7.1.1. Авлигын гэмт хэргийг бууруулна.	АХ-5.6.4, МУХТЖҮЧ-5.6.2, ЗГҮАХ -4.2.1	7.1.1.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх	Авлигын индекс	Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 3 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай.	100
7.2.Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.	7.2.3. Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	АХ-3.6.1, МУХТЖҮЧ-3.6.2,ЗГҮАХ-4.1.1	7.2.3.2.Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх	Хаягийн мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглээ	МУ-ын Ерөнхий сайдын 2024 оны 60 дугаар захирамжаар "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд нарийн бичгийн даргаар УБЕГ-ын дарга ажиллаж байна. Тус ажлын хэсгийн анхдугаар хурал 2024.11.22-ны өдөр	100

					зохион байгуулагдаж, УБЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд нар оролцож "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг Улсын бүртгэлийн ерөнхий газартай холболт хийж дундын мэдээллийн санг байгуулах ажлын талаарх танилцуулга"-ыг хийсэн. УБЕГ, ГЗБГЗЗГ-ын даргын хамтарсан 2022.05.31-ний өдрийн А/118, А/462 дугаар тушаалаар байгуулагдсан Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг нь 2024.11.20-ны өдрийн байдлаар 4 удаа уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтуудаар газрын кадастрын мэдээллийн системд өмчлөлийн газрын бүртгэл мэдээллийг түүхчилсэн байдлаар хөрвүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв бүртгэхэд бүртгэлийн байгууллагаас гарах өгөгдөл мэдээллийг авах замыг тодорхойлж, мэдээлэл солилцохоор Үндэсний дата төвд байрлах баазад газрын үйлчилгээний түүхчилсэн мэдээллийн сервисийг үүсгэж, ГЗБГЗЗЕГ-аас авах хаягийн мэдээллийн багануудыг тодорхойлж хүргүүлсэн. Хаягийн санг нэгтэх зорилгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь кадастрын дугааргүй бүртгэлийг нөхөж оруулах ажлын явц 2024.11.25-ны өдрийн байдлаар нийт 128,783 нэгж талбарын дугаар буюу нийт нөхөж оруулах шаардлагатай бүртгэлийн 62.7%-ийг нөхөж оруулаад байна. Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 2024.11.25-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 7,666 хаяг өөрчлөгдсөн бүртгэл хийгдсэн байна.	
Биелэлтийн дундаж үнэлгээ						100
Оноо						5